

МОНГОЛЧУУДЫН НЭР НУУЦЛАХ ЁСОН ХИЙГЭЭД ХХ ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН СЭТГҮҮЛЧДИЙН НУУЦ НЭРИЙН ТУХАЙД

А. Энхбат

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль.

E-mail: batu_hany@yahoo.com

Өгүүллийн товч утга: Энэ өгүүлэлд Монголчуудын нэр нууцлах, цээрлэх ёс болон ХХ зууны эхэн үед амьдарч өөрийн үзэл санааг тусгасан бүтээпүүдээ түүрвчин байсан өнөөгийн өндөрлөгөөс харвал сэтгүүлч гэж болохоор тэр, нийгмийн зүтгэлтнүүд болох Ж. Цэвээн, Д. Бодоо, Ч. Дандаа нарын намтрэг цухас өгүүлсэн ба улмаар тэдний бүтээлүүдийнхээ төгсгөлд тавьж байсан нууц нэрсийн далд утга санааг тодруулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Нэр цээрлэх, нэр нууцлах, зан заншил, сэтгүүлч, нууц нэр.

Сонин хэвлэлд зохиогчийг төлөөлөх нууц нэр хэрэглэх явдал нь дэлхийн аль ч улсад түгээмэл байдаг үзэгдлийн нэг билээ. Монгол улсад тогтмол хэвлэл үүсэн бий болсон ХХ зууны эхэн үед сэтгүүлчид, эрдэмтдийн дунд анхлан нууц нэр хэрэглэж эхэлсэн бөгөөд өнөө үед ч гэсэн сонин хэвлэлд нууц нэртэй өгүүлэл, нийтлэл хэвлэгдэж байна. Өөрийн нэрийг нууцлах нь тухайн цаг үеийн нийгэм, улс төрийн уур амьсгалтай холбоотой.

Энэ удаад бид ХХ зууны эхэн үед амьдарч агсан нийтлэгчид буюу өнөө үеийнхэндээ сэтгүүлч хэмээгдэн нэрлэгдэж буй тэргүүний сэхээрсэн үзэл бодолтой хүмүүсийн нууц нэр, түүний утга, агуулга болон тэдний намтар т голлон анхаарлаа хандуулсан бөгөөд монголчуудын нэр нууцлах, цээрлэх зан үйлийн тухай бас цухас өгүүлэхийг хичээсэн болно.

Манай ард түмэн эрт үеэс аливаа хүн, амьтан, юмс үзэгдлийг жинхэнэ нэрээр нь шууд хэлж, бичдэггүй хүндлэх, цээрлэх, өөрөөр нэрлэх, авгайлах зэргээр дуудаж бичдэг уламжлалтай. “Ийнхүү өөр үгээр орлуулахыгаа “илт өгүүлэх ёс (онжад) гэнэ. Өөрөөр хэлбэл, ил тод хэлэх нэр түүний цаана жинхэнэ нэр нууцлагдсан байх ёс бөгөөд жинхэнэ нэрээ төлөөлөх нэрийг “илт өгүүлэх нэр гэдэг”¹ хэмээн эрдэмтэн зохиолч Л. Түдэв өгүүлсэн байdag. Зарим үед хүний хоч, цол чимэг, албан тушаал нь уул эзнийхээ нэрийг орлох тохиолдол бий.

Мөн “Дүү хүн ахмад хүн, ах, эгч нараа хүндэтгэн ах, эгч, Ажаа, Амбаа, Бандгай, Дальдаа, Жиижээ, Додоо, Гагаа, Анжаа, Агаа, Адия гэх мэт авгайлж хүндэтгэн нэрлэж байсны зэрэгцээ эцэг, эхийн нэрийг хэлдэггүй хүндэтгэлийн өөр үгээр, жишээ нь аав, ээж (эцэг, эх), ажаа хэмээн нэрлэдэг заншилтай бөгөөд эцэг, эхийн нэртэй адил нэрийг дуудах нэрлэхээс цээрлэдэг ёс байжээ.”² Тиймээс аав, ээжтэйгээ адил нэртэй хүнийг хэцүү нэрт хэмээдэг.

Номын багш, ихэс дээдэс, ариун дагшин шүтлэгтэй уул, ус, дээдлэн шүтээн болсон араатан жигүүртнээс нэрээр нь дуудаж, ярьж бичихийг цээрлэдэг. Уул, овоог Хайрхан хэмээн хүндлэн нэрлэж усанд ам гарч басдаггүй хэмээлцдэг бол ижил тэнгэртэй хүнд харагдаж, илүү тэнгэртэй хүнд авлуулдаг гэдэг чоныг хангай, хээрийн нохой, боохой, мөн лусын амьтан хэмээн үздэг, могойг урт хорхой, хээрийн хорхой гэх зэргээр нутаг нутагт өөр өөрөөр цээрлэн хэлэлцдэг.

Өндөр уулыг үзвэл хайрхан гэж дууд

Өвгөд настантай золговол аав, ээж гэж дууд гэсэн мэргэн ардын маань сургааль байdag билээ.

Бас шашин шүтлэг, ардын элдэв домын үүднээс бага насны хүүхдийг харуй бүрий, шөнө оройн цагаар далдын хар хүч, лус савдгийн хорлогоос хамгаалан гадагш авч гарахдаа хамрыг нь хөөдөн зүс буруулан хар халzan

¹ Л. Түдэв “Аман хууль” УБ., 2000. 153-р тал

² “БНМАУ-ын угсаатны зүй”. боть I. УБ., 1987. 272-р тал

туулай болгон бэлгэддэг заншил бий бөгөөд бас нэрийг нь буруулан нууцлан миний хүү, охин гэх зэргээр дуудах явдал бий. Учир нь харуй бүрэнхий үед элдэв хий, хийсгэвэр биетний хөл хөдөлгөөн ихэсдэг гэж үздэг. Бас "энхрий "тогтдоггүй" хүүхэдтэй айл бүстэй хүүхэддээ "Хүүхэн" гэж зориуд нэр өгөхөөс гадна өр нь энхрий хүүхдэд Ухна, Майхант, Овоохойт, Хэнчбиш, Олдохгүй, Гүзээдорж, Бяруухүү, Нохойхүү, Шарнохой, Муунохой гэх мэт нэр³ өгдөг заншилтай.

Мөн өвчин зовлон, гай барцад тохиолдсон зарим нэгэн хүн нэр хүндэдлээ гэж үзэн нэрээ өөрчилдөг. Ингэхдээ өөрийн эдлэж байсан хувцас, үс, хумснаас хэсэглэн авч оршуулж буй мэт зан үйл хийх ба энэ нь анхлан авсан нэр эзэнтэйгээ насан турш хамт байдаг учраас анхны нэрээ бүрэн үгүй болгож дахин шинэ нэр авч огт өөр хүн болж байгааг бэлгэддэг.

Бас алс газар хүний нутагт ядруу дорой яваа хүн өөрийн нэр усыг тэр бүр хүнд хэлдэггүй нуудаг. Энэ нь манай ардын "Нэр хугацаа яс хугар","Хүн нэрээ, тогос өдөө" гэж нэр төрөө эрхэмлэх монгол уламжлалтай холбоотой болов уу.

Мөн манай ардын баатарлаг туульсын зарим гол дүрийн баатрууд өөрсдийн нэр болоод зүс царай, унаа морь хувцас хэрэглэлээ нуун хувилган нэрээ нууцлан өөр нэр хэрэглэх нь элбэг тохиолддог нэн сонирхолтой. Үлгэр, туульсын гол дүрийн баатрууд маань ихэвчлэн өөрсдийн хүч чадал, алдар нэр, зорин яваа үйлсээ нуун бусдад Нусгай жур, Таахай бор хүү, Нусгай бор хүү эсвэл хааны адуучин, тугалчин, тэмээчин хүү байна хэмээн танилцуулдаг. Ийм туульсын тоонд Гэсэр, Алтайн Гургалдай, Живэр хааны Живэр Мижид хүү, Нэгэн зуун тавин таван насыг насалсан хөгшин Луу мэргэн хаан зэрэг туульсыг нэрлэж болно. Жишээ нь: Алтан Гургалдай туульд "Алтан гургалдай хаан,

Хамуутайхан бор даагатай
Нусгайхан муу хүү болоод
Хаагаараа хар эсгий цувуулсан
Шагайгаараа шар эсгий цувуулсан
Боривоороо бор эсгий цувуулсан
Дэрсэн нумтай, хулсан сумтай
Нусгайхан муу хүү болон"⁴ явав хэмээн гардаг. Эндээс

үзэхэд эртний балчир сэтгэлгээний ул мөр болох туульст голдуу ялан дийлэгч

бoloх зорилготойгоор нэрээ нууцлаж ирсэн нь харагдаж байна.

Харин хувьсгалчид, тагнуулчид, өөр хоорондоо харилцахдаа түлхүүр үг, нууц нэрийг түгээмэл хэрэглэдэг нь шууд л улс төрийн зорилготой. Тэгвэл сэтгүүлчид эрхтэн дархтаны дутагдал, нийгмийн элдэв гажигийг шүүмжлэн, илчлэн бичиж олонд ил тод болгосныхоо төлөө дарамт шахалтанд орохоос амин бие, үзэл санаагаа хамгаалах зорилгоор нийтлэл, нэвтрүүлэг, өгүүлэл, мэдээнийхээ төгсгөлд нэрээ нууцлан хэвлэлд өөрийг нь төлөөлөх зохиомол нэр тавьдаг. Үүнийг нууц нэр хэмээдэг. Тиймээс нууц нэр бол сэтгүүлчдийн өөрт нь ирэх сөрөг үр дагавраас зайлсхийх төдийгүй олонд алдарших нэгэн арга зам болдог талтай.

Харин өнөө үеийн Баабар, Шаабар хэмээн нэрс бол амидай нараасаа өөрийн нэрийг ялгах гэнээс үүдэлтэй бололтой. Учир эдгээр нэр эзнээ нууцлан хамгаалдаггүй Б.Батбаяр, Ша.Батбаяр нарыг төлөөлдөгийг бүгд мэддэг. Гэхдээ Баабар гэдэг нэр нь эхэн үедээ нууц нэр байгаад хожим уг чанараа гээсэн байж болох юм. Харин Рамзей, Сод гэх зэрэг нэрүүдийн цаана хэн гэдэг сэтгүүлч, хувь хүн байгааг нийт олонх мэдэхгүй тиймээс жинхэнэ нууц нэр болж байна.

Манай албан болон хувийн бичгийн харилцааны уламжлалд өөрийн нэр болон тухайн хандаж байгаа хүнийхээ нэрийг бүтнээр бичилгүй эхний үсэг,

³ "БНМАУ-ын угсаатны зүй" боть I. УБ., 1987. 290-р тал

⁴ "Халх ардын тууль" УБ., 1991. 43-р тал

үеийг тавьдаг ёсон байжээ. Энэ бол бурханы шашины хамт монголд нэвтэрсэн төвдийн бичгийн соёлын нөлөө бөгөөд, нөгөө талаас Манж нарын мөрдөж байсан төрийн албан бичгийн дэг жаягаас улбаалсан заншил юм. Жишээ нь : 1914 оны 5 сарын 14 ний Сургуулийн хэргийг гадаад яаманд эрхүүлэх тухай тушаан илгээсэн бичиг хэмээх баримтанд "дэд сайд нягт бэлигт гүн да лам Р"⁵ (уул нэр нь Равдан) хэмээн нэрийн эхний үсгийг бичсэн бол "дэд түшмэл Бавуудорж, орчуулагч түшмэл буриад Жамсранов нарыг"⁶ хэмээн бүтэн нэрээр нь бичжээ. Эндээс үзвэл өндөр албан тушаалын хүний зэрэг цол хэргэнийг нь бичээд, улмаар нэрийг нь шууд дурдалгүй эхний үсгийг нь бичдэг байсан ба бага тушаалын хүмүүсийн нэрийг бүтнээр нь бичдэг байж. Тэгвэл 1912 оны 2 сарын 7 ний өдөр Төрийн сургууль байгуулж язгууртны хөвгүүдийг сургахыг хүсэж Гомбосүрэн, Цэрэндорж нараас Богдод айлтгасан бичиг хэмээх баримтанд "Шавь боол Го, Цэ сөгдэж хичээнгүйлэн айлтгах нь"⁷ хэмээн гарч байна. Энд Богд хаанд бичиг илгээгчид өөрсдийн нэрийн эхний үеийг бичсэнийг үзвэл ихэс дээдэст айлтгах бичигт өөрсдийн цол хэргэнийг дурдалгүй зөвхөн нэрийн эхний үеийг бичдэг журмыг баримтлаж байсны гэрч юм. Харин хувийн захидал харилцаанд мөн л адил дээрх ёсыг мөрддөг байжээ. Жишээ нь: Манлайбаатар Дамдинсүрэнгээс өрөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэнд бичсэн нэгэн хувийн захидалын эхэнд "Сайд жанжин Да өргөх нь"⁸ хэмээн бичсэн байдаг.

ХХ зууны эхэн үед Монгол оронд уншигдаж байсан "Монголын сонин бичиг", "Шинэ толь хэмээх бичиг", "Нийслэл хүрээний сонин бичиг", "Монголын Үнэн", зэрэг анхны тогтмол хэвлэлүүд болон ухуулах хуудас, улсын дээд, доод хурал, Богд хаан, Ардын засаг зэрэгт өргөх бичгүүдийн заримд нь нууц нэр хэрэглэсэн, эсвэл огт нэр тавиагүй байх явдал нэлээд гарч байжээ. Тухайн үед Өвөр Монголын Харчин хошууны Алмас-Очир мээрэн, Хайсан гүн, Буриадын Агын аймгийн Цэдэвийн Цэдэн-Иш, Д.Намсрай, Далхжав, үе улирах гүн Бадрах-баатар, Д.Бодоо, Ж.Цэвээн, Ч.Дандаа, Олноо өргөгдсөн Монгол улсын Шүүх яамны бичээч Жанцансамбуу, Б.Дорж, нарын олон сэтгүүлч нийтлэгч нар өөрсдийн өгүүлэл нийтлэл, үзэл санаагаа илэрхийлж байсан билээ.

Дээр дурдсан хүмүүсээс бидэнд лавтай мэдэгдэж байгаагаар 1921 оны хувьсалаас өмнө Ж.Цэвээн, Д.Бодоо, Ч.Дандаа нар нууц нэр хэрэглэж байсан нь баттай байна. Тиймээс дээрх гурван хүний намтарыг товч сөхөн үзэхээр шийдлээ.

"Нийслэл хүрээний сонин бичиг"-т нийтлэгдэн нууц нэрээр бичсэн зарим нэг өгүүллүүдийн зохиогчийг ахмад сэтгүүл эрдэмтэн Г.Дэлэг тухайн үед уг сонинд хэвлэх ажил хийж байсан Н.Намсрай, Д.Ээндэн нараас авсан мэдээг баримтлан Д.Бодоог "Болд-Илд", Ж.Цэвээнийг "бага түшмэлийн хүү Хардорж" гэсэн нууц нэр хэрэглэснийг тогтоосон байдаг.⁹ Мөн дээр нэр гарсан Ж. Цэвээн 1914 онд "Шинэ толь хэмээх бичиг"-т "Мухар огдой" гэсэн нэрээр Богд хаанд хандсан шүүмжлэлт өгүүлэл бичсэн байдаг.

Ж.Цэвээн бол Монголын сэтгүүл зүйн түүхэнд давтагдашгүй ул мөр үлдээсэн том сэхээтний нэг юм. Орос, Монголын төрд аль алинд нь зутгэж явсан, монгол улсын иргэн гэхэд эргэлзээ төрмөөр гайхалтай сонин намтартай хүн бөгөөд түүний үзэл бодол, үйл хэрэг нь ч тухайн үеийнхнээсээ нэн ялгардаг. Тэрбээр 1881 онд Буриад монголын Шарайд овогт Жамсрангийн гэрт мэндэлжээ. Ж.Цэвээн "Шинэ толь", "Нийслэл Хүрээний сонин бичиг" зэрэг анхны тогтмол хэвлэлүүдэд эрхлэгч, сэтгүүлч, сурвалжлагчаар ажиллаж байсан ба

⁵ "Монголын автономит үеийн сургууль" (1911-1920) УБ., 1966 /баримт бичгийн эмхтгэл. т.17

⁶ Мөн тэнд

⁷ Мөн тэнд .8-р тал

⁸ УТА , фм-170 д1 хн 538 нугалбар 11

⁹ Г.Дэлэг "Монгол тогмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл" УБ., 1965. 138-139-р тал

Олноо өргөгдсөн Монгол улсын Гадаад явдлын яамны соёл эрхэлсэн түшмэл, Ардын засгийн газрын Дотоод яамны дэд сайд, Судар бичгийн хүрээлэнгийн жинхэнэ гишүүн, эрдэмтэн нарийн бичгийн дарга, Ардыг гэгээрүүлэх яамны зөвлөх түшмэл, Засгийн газрын эдийн засгийн болон, Монгол банкны зөвлөлийн боловсронгуй гишүүн, НТХ-ны тэргүүлэгч, гишүүн, Намын хянан байцаах төв комиссын орлогч, тэргүүлэгч, Улсын бага хурлын гишүүн, зэрэг нам, төрийн өндөр алба хашиж явсан байна. Мөн Лөнинград хотын Дорно дахины хүрээлэнд ажиллаж хэл бичгийн ухааны докторын зэрэг хүртсэн бол дараа нь ЗСБНХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн болж байжээ. Ж.Цэвээн өндөр боловсролтой орос, монгол хэл бичигт нэвтэрхий, соён гэгээрүүлэгч нэрт эрдэмтэн, сэтгүүлч, төр, нийгмийн зүтгэлтэн байлаа. Харамсалтай нь ховорхон төрөх ийм сод хүнийг 1937 онд "тагнуул, хорлон сүйтгэгч" хэмээн хэлмэгдүүлэн баривчлаж 1940 онд цаазалсан байна. Хожим 1956 онд түүний нэр төрийг сэргээж цагаатгасан байдал.

Судлаачдын олонхи нь Ж.Цэвээнийг үндэсний ардчилсан үзэлтэй байсан хэмээн дүгнэдэг.

Ж.Цэвээн нь амьран байсан цаг үедээ үзэл санаагаа тусгасан өгүүлэл нийтлэлээ "тэр бүрий өөрийн нэрээр бичих боломжгүй байсан учраас "Мухар огдой", "Уулын өвгөн", "Аюурзнаев", "Бөгзееев" мэтчилэнгийн нууц нэрээр, бас нэргүйгээр бичдэг байжээ."¹⁰ хэмээн эрдэмтэн Д.Дашжамц бичжээ. Тэрбээр нууц нэрүүдээ 1921 онд Ардын хувьсгал ялсны дараа ч гэсэн хэрэглэж байлаа. Тухайн үеийн гол хэвлэлүүд болох "Хувьсгалт Залуучуудын эвлэл" сэтгүүл (1927 оны 9 дэх дугаар), "Үнэн" сонин (1926.5.21-ний 8 дугаар)-т бичсэн өгүүллүүдийнхээ төгсгелд "Уулын өвгөн" хэмээн нэрээ буруулан тавьсан байдал. Энэ нь түүнийг тухайн үеийн улс төрийн нам хүчин болон тэдгээрийн удирдагчидтай зарим талаараа санаа бодол зөрдөг байсны гэрч юм.

Мөн түүнтэй захидлаар харилцаж байсан Оросын хувьсгалч Б. Шумяцкий болон зарим хүмүүс Хүндэт н. Бегзееев¹¹ хэмээн бичиж байсан байдал. Эндээс үзэхэд уг нэр нь хувьсгалын үйл хэрэгт ашигладаг нэр байсан бололтой гэхдээ 1914 онд "Шинэ толь"-ын 10 дугаар "Бэгз" гэсэн нэр хэрэглэсэн байдал. Мөн "Аюурзнаев, Аюурвасэд" гэх нэрийг нь С.Түвшин зэрэг судлаачид утга зохиолын нууц нэр хэмээдэг. Мөн "1914 онд Ж. Цэвээн Амоснавчиг хэмээх нууц нэр хэрэглэн, Монгол, Орос, Хятад гурван улсын хэлэлцээрт оролцож байлаа."¹² Үүнээс үзэхэд тэрбээр өөрийн үйл хэрэг, тууривал бүтээлийнхээ төрөл зүйл, утга агуулга зэрэгт тохируулан олон нууц нэр хэрэглэдэг байсан байна.

Монголын шинэ үеийн түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэсэн улс төрчдийн нэг Догсомын Бодоо манай сэтгүүл зүйн хөгжилд багагүй хувь нэмэр оруулсан түүхэн хүмүүсийн нэг мөн билээ. Тэрбээр 1885 онд Нийслэл Хүрээний Элбэг амгалант гацаанд (одосгийн Амгаланбаатар) мэндэлжээ. Олноо өргөгдсөн Монгол улсын төр, шашины байгууллагад бичээч, түшмэл, срос консулын дэрэгдэх орчуулагчийн сургуульд монгол хэлний багш, "Монголын сонин бичиг", "Шинэ толь", "Нийслэл Хүрээний сонин бичиг" зэрэг анхны тогтмол хэвлэлүүдэд сурвалжлагч, нийтлэгчээр ажиллаж байсан тэрээр Консулын бүлгэмийг анхлан санаачлан үүсгэж, үндэсний ардчилсан хувьсгалын удирдагчдын нэг болсон. Улмаар Ардын түр засгийн газрын түшмэл, ерөнхий сайд, МАН-ын төв хорооны дарга, Ардын засгийн анхны ерөнхий сайд, Гадаад явдлын яамны тэргүүн сайдын өндөр албыг хашиж явжээ.

¹⁰ Д. Дашжамц "Нэрт эрдэмтэн, нийгмийн зүтгэлтэн Жамсраны Цэвээн". Жамсраны Цэвээн Түүвэр зохиолууд. УБ., 1997. 12-р тал

¹¹ Д. Дашжамц "Нэрт эрдэмтэн, нийгмийн зүтгэлтэн Жамсраны Цэвээн". Жамсраны Цэвээн Түүвэр зохиолууд. УБ 1997 130-р тал

¹² С. Түвшин "Ж.Цэвээний гадаад бодлогын үзэл баримтлалын тухайд". МУИС-ийн ЭШБ. Түүх III. УБ., 2004. 99-р тал

Төр засгийн талаар “түүнтэй ижил бодолтой хүмүүсийг “Бүгд найрамдах ёсны” үзэлтэн хэмээдэг гэсэн эрдэмтэн Л. Бат-Очирын дүгнэлттэй олонх судлаачид санал нийлдэг.

Тэрбээр “Болд-Илд” хэмээх нууц нэрийн дор болон нэргүйгээр өөрийн үзэл бодлыг тусгасан хурц, дайчин өгүүлэл, нийтлэлүүдээ туурвиж байсан юм.

Мөн XIX-XX зуун зааг үед нууц нэр ашиглан өөрийн үзэл бодлыг илэрхийлж байсан сэтгүүлчийн нэг бол олон түмэнд Дандаа хэмээх бичгийн нэрээр алдаршсан Ч. Дэмчигдорж билээ. Түүнийг сэтгүүлч гэхээсээ нэрт соён гэгээрүүлэгч, орчуулагч суу билэгт эрдэмтэн хэмээн үзэж Дандаагийн гүн ухазн, дэвшилтэй ардчилсан үзлийг манай үеийн олон эрдэмтэд судлан үзсэн байдаг. Тэрбээр 1864 онд Өвөр Монголын Зостын чуулганы Харчин дундад хошууны Харчин овогт Чимэдийн гэрт мэндэлжээ. Түүнийг албан баримт бичгүүдэд Дотоод чуулганы Дандаа, Цахар түшмэл Дандаа гэх зэргээр тэмдэглэсэн байдаг. Мөн Тэнгэрийн бошигт түшмэл гэсэн нууц нэртэй байсан гэсэн аман мэдээ бий. Түүний Дандаа хэмээх нэрийн утга нь ханьсах саран буюу тэнцшгүй, харьцашгүй өрсөлдөгч тэмцэгч гэсэн утгатай төвд үг хэмээн доктор Д. Дашибадрах тайлбарлажээ

Ч. Дэмчигдорж нь Бээжин хотод “Да гү ба” сонинд монгол, төвд, хотонгийн асуудал эрхэлсэн сэтгүүлч, тус сонины Чуулалт хаалга хот дахь сурвалжлагч, Цахар найман хошуу ба Жан хян гуугийн ногоон тугийн манж, монгол түшмэдийг бүгд захирах сайдын яамны зөвлөн хэлэлцэх түшмэл, Цахар сайд Гүүшир мэргэн хамба хутагтын газар эрхлэн зөвлөн хэлэлцэх багш, Судар бичгийн хүрээлэнгийн жинхэнэ гишүүн зэрэг албыг хашиж байсан нэгэн бөгөөд 1914 онд Халх монголд иржээ. 1921 он хүртэл улсын дээд, доод хуралд өөрийн дэвшилт ардчилсан үзлийг тусгасан айлгалт, өргөх бичиг зэргийг үе үе илгээн, гэрээр ном судар орчуулах, бичиг эрдэм заах зэрэг ажлыг эрхлэж байгаад 1921 оноос Судар бичгийн хүрээлэнд ажиллах болсон юм. Тэрбээр манж, хятан, япон, төвд, монгол хэл бичигт төгс боловсорсон нэгэн бөгөөд 1932 онд Улаанбаатар хотноо таалал төгссөн билээ.

Түүний тухай эрдэмтэн Д. Дашибамц “Ч. Дэмчигдорж “Шинэ засгийн бодлогын зүйл” хэмээх бичгийнхээ эцэст өөрийн чухам нэр болон бичгийн нэрийн аль алиныг бичээгүй “гэмээ мэдсэн хөдөөний хүн бичив” гэж алдар нэр буруулан бичсэн нь учиртай юм. Тухайн үед түүний үзэл санаа дэмжигдэхгүй хавчигдаж байсантай холбоотой бизээ”¹³ хэмээн тун оновчтой дүгнэлт хийсэн байна. Түүний энэ нууц нэр нь тухайн үеийн бичгийн болон ярианы хэлэнд ихэс дээдэст хандахдаа тухайн хүн өөрийн биеийг өчүүхэн хүн, мөхөс би, шавь боол, муунхаг хүмүүн гэх зэрэг дөрд үгсийг хэрэглэж ирсэн уламжлалын нэг хувилбар бололтой. Эрдэмтэн Д. Дашибамц цааш өгүүлэхдээ “Дэмчигдорж тэр үед манжийн Гирин мужид гарч байсан “Монгол үгийн бодрол” сэтгүүл, Харбин. “Монголын сонин бичиг”, “Шинэ толь”, “Нийслэл хүрээний сонин бичиг” зэрэгт өгүүлэл шүүмжлэл бичиж байсан бололтой юм. Түүнийг нь одоо судлан тодруулах хэрэгтэй байна.”¹⁴ хэмээн бичжээ. Энэ бол тун зүйтэй санал юм. Гэвч дээрх сонин сэтгүүлийн өгүүлэл, нийтлэлүүд ихэвчлэн нэргүй байх нь элбэг байх бөгөөд эс бөгөөс нууц нэр тавьсан нь бий. Бидний мэдэж байгаагаар Ч. Дандаа 1922 онд бичсэн “Шинэ засгийн гол ёс” хэмээх бүтээлдээ нэр тавиагүй байсан. Тиймээс “Улсын номын сангийн бүртгэлд “Ард түмний ариун ёс” гэдэг товхимол бичсэн Дарав бандидын зохиол гэж ташааран хаяг “¹⁵ хийснийг түүний шавь эрдэмтэн Л. Лувсанчүлтээм олж тогтоосон байдаг. Тэгэхээр Ч. Дандаа

¹³ Д. Дашибамц “Монгол дахь дэвшилт ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд” (XIX-XX зууны зааг) УБ., 1970. 36-р тал

¹⁴ Мөн тэнд

¹⁵ Л. Лувсанчүлтээм “Эрдэмтэн Дандаагийн тухай хэдэн үг”. Монгол судлал. боть VII. УБ., 1970. 95-р тал

дээрх сонин сэтгүүлүүдээр өөрийн үзэл санааг бусадтай хуваалцаж байсан гэх бүрэн үндэстэй.

Одоо жинхэнэ нууц нэrsийг шинжлэн үзье. Тэдгээрийг дотор нь дараах байдлаар ангилан үзэж болмоор байна.

1. Төвдийн бичгийн уламжлал болон Манжийн албан бичиг хөтлөх журам зэргээс улбаалсан нэрийн эхний үсэг, үеийг тавьсан нууц нэр. Ийм нэрийг хэвлэлд өгүүлэл, нийтлэлийн ард тавьж байгаагүй ч Ц. Цэвээн "Нийслэл Хүрээний сонин бичиг"-ийн 1915 оны нэгдүгээр сарын 23-ны дугаарт тухайн үеийн сургуулийг шүүмжилсэн цуврал өгүүлэлийн дөрөвдүгээрийг бичихдээ өмнөх цувралыг бичсэн Бадрахбаатар, Магсар бээс, Бодоо нарын нэрийг нууцлан "сургуулийн хэрийг шүүмжилсэн нэргүй хэдэн хүнд нэр таамаг өгвөл Ма, Ба, Бо мэт болно." хэмээн өгүүлссэн байдгаас үзвэл тэр үед сэтгүүлчид нэг нь нөгөөгөө нууцлан нэрийн эхний үсгийг тавьж байсныг харуулна. Мөн Улсын дээд, доод хуралд өргөж байсан зарим бичигт уул хүний нэрийн эхний үсэг тавьсан тохиолдол нэлээд бий. Иймээс нэрийн эхний үсэг, үе тавьсныг нууц нэр хэмээн үзэх боломжтой юм. Харин хожим энэ ёсон ярианы хэлэнд Ши багш (Б.Ширэндэв), Да багш (Ц.Дамдинсүрэн), Ри багш (Б.Ринчин), Лу багш (Ш.Лувсанвандан), Га багш (Ш.Гаадамба) гэх зэргээр багшийнхаа нэрийг бүтэн дууддаггүй хүндэтгэлийн хэлбэрээр уламжлагджээ.

2. Ихэс дээдэс, засаг төрд хандсан өгүүлэл, нийтлэл, өргөх бичиг зэрэгт голчлон хэрэглэсэн "мухар огдой", "уулын өвгөн" (Ж. Цэвээн энэ үед Богд хан уулын нэгэн аманд жожигдуу амьдарч байжээ.) "гэмээ мэдсэн хөдөөний хүн" зэрэг нэрүүд юм. Эдгээр нь засаг төр, ихэс дээдсээ хүндэтгэн тэдний үйл хэрэгт өөрийн санаа бодлыг нэмэрлэх, зарим нэг алдаа эндүүрлийг ухуулан ойлгуулах гэсэн бичгийн хүний даруу үзлээс үүдэлтэй нэрүүд бололтой.

3. Өөрийн үзэл бодлыг хатуу чигчээр илэрхийлсэн хурц дайчин өгүүлэл нийтлэлд "Болд-Илд", "Тэнгэрийн бошигт түшмэл", "Хардорж" (дорж гэдэг нь төвд үг бөгөөд монголоор хатуу бүгдийг отлогч буюу алмааз гэсэн утгатай), "Бэгз, Бегзеев" Бэгз гэдэг нь бас төвд үг бөгөөд хуяг гэсэн утгатай¹⁶ (эзнээ хуяг мэт хамгаална гэсэн далд утгатай байж болох юм.) "Аюурзнаев" Аюур санкрит үг бөгөөд анагаагч гэсэн утгатай¹⁷ (Бусдын алдаа, оноог ангаан, засах гэсэн далд санааг агуулсан байж болох талтай) гэх мэт эрс дайчин хурц агуулагтай нэrs хэмээн гурван хуваан авч үзлээ.

Харин XX зууны 20-30 аад оны үед амьдарч асан сэтгүүлч, эрдэмтэн зохиолч нар дээрх уламжлалд тулгуурлан Д. Навааннамжил "Улаан-нүдэн", Дамбадорж "Улаан-оторч", Н. Жадамба "Ойдов", Буяннэмэх "Цэцэнбилэг", Д. Нацагдорж "Элдэв-очир" гэсэн нууц нэрүүд хэрэглэдэг байжээ. Эдгээр эрдэмтэн зохиолчид, сэтгүүлчдийн нууц нэrsийг харахад өөрийн хоч болон шууд зохиомол нэр хэрэглэх, нэрээ орчуулж тавих зэрэг аргуудыг ашигладаг нь мэдэгдэж байна.

Abstract: Traditionally Mongolians did not call and write by own name their religious teachers, most respectfully people of the high rank and holy sacred mountains, rivers, lakes, animals and birds. The famous leaders J. Tseveen, D.Bodoo, Ch.Dandaa were using nicknames before the revolution in 1921. Those nicknames can be divided into 3 categories. According to studying of nicknames:

1. The name, which is written by a first alphabet and first two alphabets of the names, that were styles of Manchu's official documents and the tradition of Tibetan script.

2. The modest name, for writing official letter, essay and article, in which criticized Governments officials and aristocrats

¹⁶ Ж. Сэргээ "Монгол хүний нэriйн лавлах толь" УБ., 1991. 16-р тал

¹⁷ Мөн тэнд

3. The name, which expressed the owners' conception.

Ном зүй

1. БНМАУ-ын угсаатны зүй. боть I. УБ., 1987
2. Д.Дашжамц. Монгол дахь дэвшилт ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд. (XIX-XX зууны зааг) УБ., 1970
3. Д.Дашжамц. Нэрт эрдэмтэн, нийгмийн зүтгэлтэн Жамсраны Цэвээн-Жамсраны Цэвээн. Түүвэр зохиолууд. УБ., 1997
4. Г.Дэлэг. Монгол тогмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 1965
5. Л.Лувсанчултэм. Эрдэмтэн Дандаагийн тухай хэдэн үг. Монгол судлал. боть VII УБ., 1970
6. Монголын автономит үеийн сургууль (1911-1920). УБ., 1966 (баримт бичгийн эмхтгэл)
7. Халх ардын тууль. УБ., 1991
8. Ж. Сэргээ. Монгол хүний нэрийн лавлах толь. УБ., 1991
9. Л. Түдэв. Аман хууль. УБ., 2000
10. С. Түвшин. Ж.Цэвээний гадаад бодлогын үзэл баримтлалын тухайд. МУИС-ийн ЭШБ.Түүх III. УБ., 2004
11. УТА , М-170, Д-1, хн. 538 нугалбар 11